



## Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар **Байгаль орчны мэдээ**

2007.02.01

**Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газрын удирдлага болон ажилтнууд Хэнтий аймгийн Дадал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчидтэй уулзалт хийв.**



**Уулзалтанд:**

WWF-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас:

- Б.Чимид-Очир, Хөтөлбөрийн газрын захирал
- Д.Батболд, Байгаль хамгааллын захирал
- Б.Ганхуяг, Дагуурын хээрийн эко-бүс нутгийн зохицуулагч



Дадал сумаас:

- Н.Доржханд, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга
- Д.Оюунгэрэл, Сумын Засаг дарга
- ИТХ-ын төлөөлөгчид.

Уулзалтаар Дадал сумын ИТХ-ын төлөөлөгчдэд WWF-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын үйл ажиллагааны тухай мэдээлэл хийв.

Мөн Дагуурын хээрийн эко-бүс нутгийн тухай болон Амар мөрний эх болох Онон голын ай савын тухай ярилцав.

Дадал сумын ИТХ-ын төлөөлөгчид Онон-Балжийн сав газрын өнөөгийн байдал нутгийн иргэдийн аж амьдрал, тулгарч буй бэрхшээлүүдийн тухай дэлгэрэнгүй ярилцав.

Уулзалтанд оролцогсад цаашид Онон-Балж голын ай савыг хамгаалах, нугийн малчид иргэдтэй хамтарч ажиллах талаар санал нэгтгэж байлаа.